**ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

(2025 оны эхний хагас жил)

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ |
| НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ | | | | | | |
| 1. | ***Зорилт 1.1: Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж холбогдох байгууллагад хүргүүлэх;*** | | | | | |
| 1.1.1 | “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | - | 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаарх зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 90 хувьтай үнэлсэн. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангагдсан байна. | III улирал |
| 1.1.2 | Монгол Улсыг (2021-2025) хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | - | 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 онд Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг 97.5 хувьтай үнэлсэн. | Бодлогын баримт бичгийн зорилт арга хэмжээний хэрэгжилт хангагдсан байна. | IV улирал |
| 1.1.3 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт- | - | 2025 оны 07 дугаар сарын 01, 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хяналт- | Засгийн газрын /2020-2024/ үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 онд Нийгмийн | Бодлогын баримт бичгийн зорилт арга хэмжээний хэрэгжилт хангагдсан байна. | II, IV улирал |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | шинжилгээ, үнэлгээ хийх; | | шинжилгээ, үнэлгээ хийнэ. | даатгалын салбарын хэмжээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг 91.2 хувьтай үнэлсэн. | | |
| 1.1.4 | Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | - | 2025 оны 06 дугаар сарын 15, 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт бүрэн биелсэн тул 100 хувьтай үнэлсэн. | Бодлогын баримт бичгийн зорилт арга хэмжээний хэрэгжилт хангагдсан байна. | II, IV улирал |
| 1.1.5 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт- | - | 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны ажлын төлөвлөгөөны биелэлтийг 94.8 хувьтай үнэлсэн. | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээ бүрэн биелж албан хаагч нар авлигаас ангид байж авлигагүй салбар болсон байна. | II, IV улирал |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | шинжилгээ, үнэлгээ хийх; | | | | | |
| ***Зорилт 1.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;*** | | | | | | |
| 1.2.1 | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | - | 2025 оны 02 дугаар сарын 15, 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар 98.6 хувьтай үнэлсэн. | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангагдсан байна. | 1.Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол нийт 27 шийдвэрийн 35 заалт байна. Үүнд:<br><br>- 2023 онд хяналтад авсан 9 шийдвэрийн 9 заалт;<br>- 2024 онд хяналтад авсан 18 шийдвэрийн 26 заалт;<br><br>Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар 100 хувь буюу “Бүрэн хэрэгжсэн” гэж үнэллээ биелэлтийг 100 хувь буюу “Бүрэн хэрэгжсэн” гэж үнэлж, үнэлгээний тайланг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/337 дугаар албан бичгээр хүргүүлэв. |
| 1.2.2 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх; | - | Улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Шилэн дансны хөтлөлтийн 2024 оны нэгдсэн тайлангаар мэдээлэл байршуулалтыг 98 хувьтай үнэлсэн. | Хяналт-шинжилгээ хийж удирдлагад танилцуулан дүгнэлт, зөвлөмж өгөгдсөн байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газар, Мэдээллийн технологийн төв, БНСУ дахь ХНХҮ-ний төвийн Нийгмийн даатгалын тасаг, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын байгууллагын үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансны цахим хуудас (shilendans.gov.mn)-т хуулийн хугацаанд үнэн зөв, бодитой мэдээлсэн эсэхийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааг хамруулан холбогдох баримт бичигтэй тулган шалгав.<br>Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны эхний 03 сарын байдлаар шилэн дансны цахим хуудаст Нийгмийн даатгалын байгууллагын болон нийгмийн даатгалын сангийн нийт 58,567 шийдвэр гүйлгээний 58,845.6 тэрбум төгрөгийн 2,851 мэдээлэл байршуулахаас 2,567 мэдээллийг хугацаанд мэдээлж мэдээлэл байршуулалт 96 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 90 хувьтай байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хяналт шинжилгээгээр нийт 22,260.0 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс:<br>- 2,655 шийдвэр гүйлгээний 16,746.5 тэрбум төгрөгийн 101 мэдээллийг мэдээлээгүй;<br>- 1,311 шийдвэр гүйлгээний 2,842.9 тэрбум төгрөгийн мэдээллийг илүү мэдээлсэн;<br>- 5,899 шийдвэр гүйлгээний 2,670.5 тэрбум төгрөгийн 183 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба хяналт шинжилгээний явцад зөрчлийг залруулж нөхөн мэдээлсэн 2,623 шийдвэр гүйлгээний 1,236.8 тэрбум төгрөгийн мэдээлэл байна.<br><br>Хяналт шинжилгээг хийх явцад Нийт мэдээлээгүй буюу 2,623 шийдвэр гүйлгээний 1,236.8 тэрбум төгрөгийн мэдээллийг нөхөн мэдээлж зөрчлийг залруулж, мэдээлэл оруулах албан тушаалтан (Сангийн болон үйл ажиллагааны нягтлан бодогч), Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга нарыг мэргэжил арга зүйгээр ханган дахин илэрсэн алдаа, зөрчлийг гаргахгүй ажиллахыг анхааруулж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн.<br>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүн, танилцуулга, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналыг удирдлагад танилцуулж Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02/912 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд, мөн Дотоод аудит, мониторингийн газрын даргын 02/1090 дүгээр албан бичгээр Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт тус тус хүргүүлсэн |
| 1.2.3 | Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | - | Хагас бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. /07 дугаар сарын 10, 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор/ | Байгууллагын цахим хуудсанд мэдээлэл байршуулалт 2024 оны эхний 11 сарын байдлаар 79.3 хувийн гүйцэтгэлтэй байна. | Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдал хангагдан, мэдээллийг бүрэн байршуулж, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна. | 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудас (ndaatgal.mn)-т мэдээллийг байршуулж байгаа эсэхэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.<br>Хяналт-шинжилгээгээр байгууллагын цахим хуудсанд мэдээлэл байршуулалт Нийгмийн даатгалын нийгмийн даатгалын ерөнхий газрын хэмжээнд 93.4 хувийн гүйцэтгэлтэй, мөн мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлт (мэдээллийн хүртээмжтэй байдал, хугацаандаа нийтлэгдсэн байдал, мэдээллийн бүрэн бүтэн байдал, эх сурвалжийн тодорхой байдал)-аар үнэлэхэд 92.8 хувьтай байсан ба үнэлгээний дүн, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | танилцуулгыг 2025 оны 01 дүгээр сарын 25–ны өдөр цахимаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.<br>2. Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын байгууллагын цахим хуудас (ndaatgal.mn)-т нээлттэй мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, хуулийн хугацаанд бодитой байршуулж байгаа эсэх (нээлттэй мэдээллийн ил тод байдал)-д 2025 оны 01 дүгээр улирлын байдлаар хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн.<br>Хяналт-шинжилгээгээр байгууллагын цахим хуудаст Нийгмийн даатгалын байгууллага нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь хэсэгт заасан 34 төрлийн 66 нээлттэй мэдээллийг мэдээлэх үүрэгтэй бөгөөд салбарын хэмжээнд 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар мэдээлэл байршуулалт 77.2 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын дагуу нээлттэй мэдээллийн ил тод байдлыг 4 шалгуур үзүүлэлт (мэдээллийн хүртээмжтэй байдал, хугацаандаа нийтлэгдсэн байдал, мэдээллийн бүрэн бүтэн байдал, эх сурвалжийн тодорхой байдал)-ээр үнэлэхэд салбарын хэмжээнд дунджаар 78.5 хувиар үнэлэгдэв.<br>3.Байгууллагын цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь байршуулж мэдээлээгүй, хугацаа хоцроож мэдээлсэн, дутуу мэдээлсэн, мэдээллийг шинэчлээгүй, мэдээлэл хариуцагчаас тавьсан мэдээллийн эх сурвалж тодорхойгүй, мэдээллийн бүрэн бүтэн байдал хангалтгүй, хамааралгүй мэдээлэл байршуулсан зэрэг нийтлэг алдаа дутагдал давтагдсаар байна.<br>Иймд илэрсэн алдаа дутагдалд дүгнэлт хийж, мэдээлэл байршуулах үйл ажиллагааг сайжруулж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах талаарх зөвлөмжийг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны “Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах тухай” 02/259 дүгээр Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлсэн. |
| **Зорилт 1.3.** ***Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;*** | | | | | | |
| 1.3.1 | Төсвийн ерөнхийлөн захирагч /Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн | - | Хагас бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. /07 дугаар сарын | 2024 оны эхний хагас жилийн явын биелэлтийг 95.8 хувь, жилийн эцсийн биелэлтийг | Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг бүрэн | Төсвийн ерөнхийлөн захирагч /Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд/-аас Төсвийн төвлөрүүлэн захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-тай 2025 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 90 зорилтын 69 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд: |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хамгааллын сайд/-аас төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | | 09, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор/ | 93.4 хувиар буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлсэн. | биелүүлж ажилласан байна. | - Бодлогын баримт бичигт тусгагдсан 1 зорилт, 19 арга хэмжээ;<br>- Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн 2 зорилт, 9 арга хэмжээ;<br>- Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийн 2 зорилт, 11 арга хэмжээ;<br>- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр 4 зорилт, 30 арга хэмжээ байна.<br><br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн явцыг **93.7** хувь буюу “**Бүрэн хангалттай**” гэж үнэлж, үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны **01/1464 дугаар** албан бичгээр болон цахимаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. |
| 1.3.2 | Төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-аас зохион байгуулалтын нэгжийн даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | - | Хагас бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. /07 дугаар сарын 09, 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор/ | Зохион байгуулалтын нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийн дунджийг эхний хагас жилийн байдлаар 88.5 хувь, жилийн эцсийн байдлаар нийт арга хэмжээний дундаж 91.3 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлсэн. | Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлж ажилласан байна. | Төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-аас зохион байгуулалтын нэгжийн дарга нартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.<br>Зохион байгуулалтын нэгжийн дарга нарын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 229 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:<br>- *Захиргаа удирплагын газар*: 40 арга хэмжээ;<br>- *Дотоод аудит, мониторингийн газар:* 23 арга хэмжээ;<br>- *Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар:* 28 арга хэмжээ;<br>- *Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газар:* 18 арга хэмжээ;<br>- *Хяналт шалгалтын газар:* 23 арга хэмжээ;<br>- *Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газар:* 15 арга хэмжээ;<br>- *Шимтгэл хураалт, мэргэжил, арга зүйн газар*: 33 арга хэмжээ<br>- *Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл:* 34 арга хэмжээ;<br>*Мэдээллийн технологийн төв:* 9 арга хэмжээ; |
| 1.3.3 | Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын төсвийн шууд захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн | - | Хагас бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. /07 дугаар сарын 09, 12 дугаар | Төсвийн шууд захирагч нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн дунджийг эхний хагас жилийн | Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлж ажилласан байна. | Төсвийн төвлөрүүлэн захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-аас төсвийн шууд захирагч /Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга/-тай 2025 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ үнэлгээг хийж, үнэлгээний дүн, тайланг Захиргаа удирдлагын газарт хүргүүлэв. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт зөвлөмж гаргах; | | сарын 25-ны өдрийн дотор/ | байдлаар 89.4, жилийн эцсийн байдлаар 90.7 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлсэн. | | |
| ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ | | | | | | |
| **Зорилт 2.1.** ***Салбарын үйл ажиллагаанд дотоод аудит хийх;*** | | | | | | |
| 2.1.1 | Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийх; | - | Байгууллагын санхүү үйл ажиллагаанд аудит хийнэ. /2 дүүрэг, 3 аймгийн Нийгмийн даатгалын газарт/ | 2 дүүрэг, 9 аймгийн Нийгмийн даатгалын газрын 2023 он, 2024 оны эхний 4 сарын байдлаарх байгууллагын санхүү, үйл ажиллагаанд аудитыг хийсэн. | Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийг зүй зохистой зарцуулсан байна. | III улирал |
| 2.1.2 | Нийгмийн даатгалын төв сангийн орлого, зарлагын гүйлгээ, төвлөрсөн орлогыг нийгмийн даатгалын холбогдох санд хэрхэн хуваарилж байгаа байдалд аудит хийх; | - | Төв сангийн орлого, зарлагын гүйлгээ, хуваарилалтад улирал бүр аудит хийнэ. | - | Төв сангийн орлого , зарлагын гүйлгээ, хуаарилалтад тогтмол хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | “Нийгмийн даатгалын төв сангийн орлого, зарлагын гүйлгээ, төвлөрсөн орлогыг нийгмийн даатгалын холбогдох санд хуваарилж байгаа байдалд хийх дотоод аудитын ажлын удирдамж”–ийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргаар батлуулсан.<br>Уг удирдамжид заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/183 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын хэрэгжилтэд нийгмийн даатгалын төв сангийн харилцах дансны 2025 оны 1-5 дугаар сарыг дуусталх хугацааг хамруулан дараах асуудлын хүрээнд хийж гүйцэтгэж байна. Үүнд:<br>- Төв сангийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт;<br>- Холбогдох санд хуваарилж байгаа байдал;<br>Аудитын дүн мэдээг нэгтгэн дүгнэлт, зөвлөмж гарган цаашид арга хэмжээний саналыг боловсруулан удирдлагад танилцуулна. |
| 2.1.3 | “Капитал банкны эрх хүлээн | - | Хөрөнгийн хадгалалт, | - | Нийгмийн даатгалын санд хүлээн авсан | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Капитал банкны эрх хүлээн авагчаас Нийгмийн даатгалын санд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | авагчаас Нийгмийн даатгалын санд хүлээн авсан хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, худалдан борлуулалт, түрээсийн гэрээний биелэлтэд аудит хийх; | | хамгаалалт, худалдан борлуулалт, түрээсийн гэрээний биелэлтэд аудит хийнэ.<br>/Цаашид хагас, бүтэн жилээр хяналт тавих/ | | хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, худалдан борлуулалт, түрээсийн гэрээний биелэлтэд тогтмол хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | хүлээн авсан хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, худалдан борлуулалт, түрээсийн гэрээний биелэлтэд хийх" дотоод аудитын ажлын 02/01 дугаар удирдамжийг баталж Капитал банкны эрх хүлээн авагчаас Нийгмийн даатгалын санд хүлээн авсан хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, худалдан борлуулалт, түрээсийн гэрээний биелэлтийг 2021 оноос 2024 оныг дуустал хугацааг хамруулан шалгав.<br>Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол, шийдвэрийг үндэслэн Капитал банк ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас Нийгмийн даатгалын сангийн нэхэмжилсэн өр төлбөрт 25.0 тэрбум төгрөгийн үнэ бүхий 78 хөрөнгийг 2021, 2022 онуудад хүлээн авсан бөгөөд өр төлбөрт тооцон хүлээн авсан хөрөнгийн үлдэгдэл 13.5 тэрбум төгрөгийн 17 ширхэг хөрөнгө байна.<br>2024 оны жилийн эцсийн байдлаар тус банкнаас нэхэмжилсэн өр төлбөрт хүлээн авсан үл хөдлөх хөрөнгөнөөс 8 ширхэг үл хөдлөх хөрөнгийг үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа 30 иргэн, аж ахуй нэгж байгууллагад түрээслүүлж байна.<br>Аудитыг дараах асуудлын хүрээнд хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Нийгмийн даатгалын санд хөрөнгө хүлээн авсан шийдвэр, акт;<br>- Худалдан борлуулсан хөрөнгийн бүртгэл, гэрээ, гэрээний биелэлт;<br>- Түрээсийн гэрээ, гэрээний биелэлт;<br>- Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдал;<br>- Өмнөх аудит болон санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, түүний барагдуулалт, хэрэгжилт;<br><br>Аудитын дүн мэдээг нэгтгэн тайланг удирдлагад танилцуулсан. |
| 2.1.4 | Эрсдлийн үнэлгээ хийх журам боловсруулж батлуулах; | - | Эрсдлийн үнэлгээ хийх журам боловсруулж 2025 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн дотор батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. | - | Эрсдэлээ тодорхойлж, үнэлдэг болсон байна. | Нийгмийн даатгалын байгууллагын зорилго, үндсэн чиглэл, үйл ажиллагаа, эрсдэл, стратеги зорилттой уялдуулан "Эрсдtлийн үнэлгээ хийх журам"-ын төслийг боловсруулсан.<br>Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны 2025 оны 03 дугаар тогтоолоор "Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын удирдлагын бодлого", "Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх заавар", "Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлал"–ыг баталсан.<br>Дээрх төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийг үндэслэн салбарын онцлогт нийцүүлэн өөрчлөх шаардлага үүссэн тул Нийгмийн даатгалын байгууллагын |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрсдэлийн үнэлгээ хийх журмыг холбогдох өөрчлөлтийг хийн 2025 оны 02 дугаар улиралд багтаан батлуулахаар бэлтгэж байна.<br>Уг журмыг батлуулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлснээр эрсдэлийн засаглал, соёл, эрсдэлийн удирдлагын хүрээ, үйл явц, эрсдэлийн мэдээлэл, харилцаа холбоо, эрсдэлийн удирдлагын хяналтын тогтолцоог тодорхойлж, эрсдэлийг удирдах хандлага, соёлд суралцахын зэрэгцээ болзошгүй эрсдэлийг илрүүлэх, шинжлэх, үнэлэх, удирдах, хянах, тайлагнах үйл явц, эрсдэлийг удирдах соёл, хандлага, чадавхыг төлөвшүүлж, эрсдэлийг үр нөлөөтэй удирдах эрсдэлийн мэдээллийн сан, дотоод хяналыг тогтвортой байнга сайжруулах зорилтыг байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх ач холбогдолтой. |
| ***Зорилт 2.2. Үндсэн үүрэг, нэгжийн дотоод ажил үүргийг биелүүлэх;*** | | | | | | |
| 2.2.1 | Нийгмийн даатгалын ерөнхий газар /ndaatgal.mn/-ын цахим хуудсанд байрших нээлттэй мэдээллийг байршуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих; | - | Нийгмийн даатгалын ерөнхий газрын нээлттэй байршуулах мэдээллийг бүрэн байршуулж, тогтмол хяналт тавьж, мэдээлэл байршуулалтыг 100 хувьд хүргэнэ. | Байгууллагын цахим хуудсанд мэдээлэл байршуулалтад 2024 оны эхний 11 сарын байдлаар 79.3 хувийн гүйцэтгэлтэй байсан. | Нийгмийн даатгалын байгууллагын нээлттэй мэдээлэл байгууллагын цахим хуудсанд бүрэн байршиж, олон нийтэд нийгмийн даатгалын байгууллагын мэдээлэл ил тод, нээлттэй мэдээлэгдсэн байна. | Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэгт хамаарах нээлттэй мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны "Нээлттэй өгөгдөл байршуулах төлөвлөгөө, хуваарь батлах тухай" А/20 дугаар тушаалыг баталсан.<br>Уг тушаалаар тус газар нь Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3-д заасан Байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, Дотоод аудитын тайлан, Санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан, Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайланг Нийгмийн даатгалын байгууллагын цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй.<br>Уг тушаалаар байршуулах мэдээллийн жагсаалт, мэдээлэл байршуулах нэгж, хугацаа, хуваарь зэргийг баталсан.<br>Тушаалын дагуу тус газраас байгууллагын цахим хуудаст Төсвийн ерөнхийлөн захирагч /Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд/-аас төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Монгол Улсыг (2021-2025) хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, Шилэн дансны хөтлөлтийн тайлан, Дотоод |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аудит, мониторингийн газраас хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан зэрэг нийт 11 төрлийн мэдээллийг гаргаж байгууллагын цахим хуудсанд байршуулж мэдээлэхээр Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газарт хүргүүлсэн. |
| 2.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагаас 2026 онд өндөр насны тэтгэвэрт гарах албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмжийн тооцоололд мониторинг хийх; | - | Засгийн газрын 2019 оны 7, 2023 оны 243 дугаар тогтоолыг хэрэгжүүлсэн байна. | 2025 онд Нийгмийн даатгалын ерөнхий газар, 5 дүүрэг, 15 аймгийн Нийгмийн даатгалын газрын нийт 41 ажилтан албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарах ба эдгээр ажилтан албан хаагчдад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжид 1,328.9 сая төгрөг олгохоор тооцооллыг хийж Тамгын газар, Бодлогын хэрэгжилт судалгааны газарт 2024 оны 06 дугаар сарын 26-ний өдөр хүргүүлсэн | Албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмжийн тооцооллыг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор мониторинг хийж Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газарт хүргүүлэх; | 2026 оны төсвийн төслийн санал тусгах төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн зөв тооцсон эсэхэд хяналт-шинжилгээ хийж, тооцооллыг шалгах, гаргасан алдаа дутагдал, илэрсэн зөрчлийг арилгуулах, үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмж өгөх, удирдлагыг бодит мэдээллээр хангах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудаас байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын 2026 оны төсвийн төслийн санал тусгах төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламжийн тооцооллыг холбогдох баримт бичгийг үндэслэн тулган шалгав.<br><br>Хяналт-шинжилгээг дараах чиглэлийн дагуу гүйцэтгэсэн болно. Үүнд:<br><br>- Төрийн албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацаа, нэг удаагийн буцалтгүй тусламж олгох дундаж цалин хөлсийг зөв тооцсон эсэх;<br>- Нийт олгох тусламжийн хэмжээг зөв тодорхойлсон эсэх;<br><br>Хяналт-шинжилгээгээр 27 албан хаагчид 928.6 сая төгрөгийн өндөр насны тэтгэвэр гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тооцооллыг хийж Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.<br>Хяналт-шинжилгээгээр илэрсэн зөрчил, алдаа дутагдал, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулж удирдлагад танилцуулсан. |
| 2.2.3 | Нийгмийн даатгалын мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох байцаагч, албан хаагчдын нэрсийн жагсаалтад хяналт тавьж, дүн | - | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/137 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын улсын | Тэргүүлэх мэргэшлийн зэрэг олгох 132, зөвлөх мэргэшлийн зэрэг олгох 417, нийт 549 байцаагчийн нэрсийн жагсаалтыг гаргаж Нийгмийн | Журамд заасан хугацаанд нэрсийн жагсаалтад шинжилгээ хийж, жагсаалтыг Захиргаа удирдлагын газарт хүргүүлж, мэргэшлийн зэрэг олгогдсон байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны “Журам батлах тухай” А/137 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журам”-д заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт ажиллаж байгаа нийгмийн даатгалын улсын байцаагчдын нэрсийн жагсаалтад 2025 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс 13-ны өдрүүдэд хяналт-шинжилгээ хийв. |

<table>
<tr>
<td></td>
<td>шинжилгээ хийж нэрсийн жагсаалтыг холбогдох газарт хүргүүлэх;</td>
<td></td>
<td>байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журам”-ын хэрэгжилт хангагдсан байна.</td>
<td>даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 01/576 дугаар албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.</td>
<td></td>
<td>Захиргаа удирдлагын газраас тэргүүлэх мэргэшлийн зэрэг олгох 48, зөвлөх мэргэшлийн зэрэг олгох 58, зөвлөх мэргэшлийн зэрэг олгох 237 нийт 343 байцаагчийн нэрсийн жагсаалт ирүүлсэн ба мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох шалгуур хангасан эсэхийг Нийгмийн даатгалын байцаагчаар ажилласан хугацааны нотлох баримт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ, ёс зүйн зөрчил, сахилгын шийтгэлтэй эсэх зэрэг холбогдох баримт бичигтэй тулган нягтлав.<br>Тус хяналтаар ажилласан жил хүрээгүй, улсын байцаагчийн эрхгүй, өндөр насны тэтгэвэрт гарсан, улсын байцаагчийн 2 удаагийн шалгалтад ороогүй зэрэг шалтгаантай 19 ажилтан байсан ба мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох албан хаагчийн болон хасагдах албан хаагчийн нэрс, тайлбарын хамт жагсаалтын хамт гаргаж Захиргаа удирдлагын газарт хүргүүлсэн.</td>
</tr>
<tr>
<td>2.2.4</td>
<td>Үндэсний аудитын газраас Нийгмийн даатгалын төв орон нутгийн байгууллагуудын 2023, 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт, аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;</td>
<td>-</td>
<td>Санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлтийг бүрэн хангаж ажиллана.</td>
<td>2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн акт, залруулгын биелэлт 100 хувьтай, албан шаардлагын биелэлт 85 хувьтай, зөвлөмжийн биелэлт 84 хувьтай байна.</td>
<td>Аудитаас өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн бүрэн биелүүлж, цаашид алдаа дутагдалыг дахин гаргахгүй байх тодорхой ажил зохион байгуулж, үр дүнг тооцож ажилласан байна.</td>
<td>Үндэсний аудитын газраас нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нэгтгэв.<br>Алдаа, зөрчлийн дүнг дараах байдлаар харуулав.<br>/Сая.төг/
<table>
<tr><th></th><th></th><th>Нийгмийн даатгалын сан</th><th>Байгууллага</th><th>Нийт</th></tr>
<tr><td rowspan="2">Нийт зөрчлийн дүн</td><td>Тоо</td><td>86</td><td>128</td><td>214</td></tr>
<tr><td>Дүн</td><td>3,869,293.4</td><td>4,241.5</td><td>3,873,534.8</td></tr>
<tr><td rowspan="2">Алдаа /залруулга/</td><td>Тоо</td><td>27</td><td>30</td><td>57</td></tr>
<tr><td>Дүн</td><td>2,799,932.7</td><td>918.2</td><td>2,800,850.8</td></tr>
<tr><td rowspan="2">Төлбөрийн акт</td><td>Тоо</td><td>1</td><td>10</td><td>11</td></tr>
<tr><td>Дүн</td><td>0.7</td><td>50.6997</td><td>51.3997</td></tr>
<tr><td rowspan="2">Албан шаардлага</td><td>Тоо</td><td>20</td><td>35</td><td>55</td></tr>
<tr><td>Дүн</td><td>889,821.2</td><td>2,156.5</td><td>891,977.8</td></tr>
<tr><td rowspan="2">Зөвлөмж</td><td>Тоо</td><td>37</td><td>53</td><td>90</td></tr>
<tr><td>Дүн</td><td>170,114.4</td><td>1,116.1</td><td>171,230.4</td></tr>
<tr><td rowspan="2">Хариуцлага тооцуулах албан шаардлага</td><td>Тоо</td><td>1</td><td>0</td><td>1</td></tr>
<tr><td>Дүн</td><td>9,424.4</td><td>-</td><td>9,424.4</td></tr>
</table>
</td>
</tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тус аудитын дүгнэлтээр салбарын хэмжээнд нийт 3,873,534.8 сая төгрөгийн төлбөр, зөрчил илэрснээс:<br><br>- Санхүүгийн тайланд 2,800,850.8 сая төгрөгийн залруулга;<br>- 51.4 сая төгрөгийн 11 акт;<br>- 891,977,8 сая төгрөгийн 55 албан шаардлага;<br>- 171,230.4 сая төгрөгийн 90 зөвлөмжийг ирүүлсэн байна.<br><br>Байгууллагын болон нийгмийн даатгалын сангийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнгийн нэгтгэлээр:<br><br>- Өөрчлөлтгүй 46;<br>- Хязгаарлалттай 5;<br>- Дүгнэлт өгөхөөс татгалзсан 1;<br>Үндэсний аудитын газраас Нийгмийн даатгалын ерөнхий газар, түүний харьяа аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлангийн нэгтгэл, аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын “Аудитын акт, албан шаардлага, зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай” А/75 дугаар тушаалыг батлуулж, Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02/ 672 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлэв.<br>Мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын дэргэдэх дотоод аудитын хорооны 2025 оны 01 дүгээр тогтоолын дагуу 2024 оны байгууллагын санхүүгийн аудитын тайлангаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг нотлох баримт бичгийн хамт ирүүлэх тухай Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02/675 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлсэн. |
| **Зорилт 2.3.** ***Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх;*** | | | | | | |
| 2.3.1 | Ажил олгогч, даатгуулагч, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, | - | Өргөдөл, гомдлыг хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэнэ. | 229 албан бичиг ирснээс 78 албан бичиг нь хариутай, иргэд, | Өргөдөл, гомдол, хүсэлт, хариутай албан бичгийн хариуг хуулийн дагуу | Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага болон ажил олгогч, харилцагч бусад байгууллагаас тус газарт хандаж 226 албан бичиг ирснээс 66 албан бичиг нь хариутай, иргэд, даатгуулагчаас 14 өргөдөл, гомдол ирүүлсэн ба |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хүсэлт болон бусад байгууллагаас ирүүлсэн хугацаатай албан бичгийг хуульд заасан хугацаанд хариуг хүргүүлэх, зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах; | | | даатгуулагчаас 65 өргөдөл, гомдол ирүүлсэний 63 өргөдлийг хуулийн хугацаанд, 2 өргөдлийг хугацаа хоцроож шийдвэрлэсэн. | хугацаанд нь шийдвэрлэж, албан бичгээр хүргүүлж ажилласан байна. | 74 албан бичгийг бусад газруудад хүргүүлсэн байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хоног 11.5 байна. |
| **ГУРАВ. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | |
| 3.1.1 | Зохион байгууллалтын нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, тайлагнах; | - | Зохион байгууллалтын нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын дагуу батлуулж, тайлагнах;. | - | Зохион байгууллалтын нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын дагуу батлуулж, 2 удаа тайлагнасан байна. | - Зохион байгууллалтын нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж Газрын даргаар батлуулсан.<br>- Газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийг гаргаж Захиргаа Удирдлагын газарт хүргүүлсэн.<br>- Төсвийн ерөнхийлөн захирагч /Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд/-аас төсвийн төвлөрүүлэн захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Дотоод аудит, мониторингийн газраас тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар гаргаж Захиргаа Удирдлагын газарт хүргүүлсэн. |
